



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 4/139

Улаанбаатар хот

Коронавируст (Ковид-19) халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, 33.1.3 дахь заалт, Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1242 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабын жижүүрийн үүрэг гүйцэтгэхтүр журмыг нэгдүгээр, авто тээврийн шалган нэвтрүүлэх байнгын ажиллагаатай товчоодод эрүүл мэндийн хяналт хийх удирдамжийг хоёрдугаар, ажиллах эрүүл мэндийн байгууллагын хуваарийг гуравдугаар, зорчигчдын эрүүл мэндэд хяналт тавих асуумжийг дөрөвдүгээр, эрүүл мэндийн хяналтад хөтлөгдөх мэдээний хүснэгтийг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга нарт даалгах нь:

2.1. Хуваарилагдсан байнгын ажиллагаатай товчоодод 24 цагаар ажиллах эмч, мэргэжилтний хуваарийг гарган баталж НЭМГ-т ирүүлэх, үйл ажиллагаанд өдөр тутмын хяналт тавих,

2.2. Авто тээврийн шалган нэвтрүүлэх байнгын ажиллагаатай товчоодод эрүүл мэндийн хяналт, тандалт, хийх удирдамжийг эмч, мэргэжилтэнд танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллах,

2.3. Үйл ажиллагаанд шаардлагатай зайнаас халуун хэмжигч, амны хаалт, бээлий, хөтлөгдөх бүртгэлийн хүснэгт, эрүүл мэндийн хяналтын асуумж, яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл зэргээр хангах, нөөц бүрдүүлэх,

2.4. Шалган нэвтрүүлэх товчоодод ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн аюулгүй байдлыг бүх талаар ханган, өөрийн байгууллагын болон техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан автомашинаар үйлчлэх, болзошгүй зам тээврийн ослоос сэргийлж цацруулагчтай ажлын хантааз заавал өмсөх, замын зорчих хэсэгт орж ажиллахыг хатуу хориглох, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах талаар сэрэмжлүүлэг, зааварчилгаа өгч ажиллах,

2.5. Байнгын ажиллагаатай товчоодод ажиллах эмч, мэргэжилтний байрлах байр, хоол хүнсийг зохицуулан, тогтмол хяналт тавин ажиллах, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх

2.6. Байнгын ажиллагаатай товчоодын үйл ажиллагааны мэдээг өдөр бүрийн 08.00 цагт авч шуурхай штабт хүргүүлэн, мэдээний үнэн зөв байдалд хяналт тавих.


3. Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабт үүрэг гүйцэтгэхэмч, мэргэжилтнүүдийн хуваарийг гарган батлуулж, хавсралтын дагуу мэдээ тайланг холбогдох байгууллагад шуурхай хүргүүлэхэд хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс /Б.Одгэрэл/-т даалгасугай.

4. Нийслэлийн Авто тээврийн шалган нэвтрүүлэх байнгын ажиллагаатай товчоодоор нэвтэрч байгаа иргэдэд хийж буй эрүүл мэндийн хяналтын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр ханган, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн Эрүүл мэндийн хэлтэс /О.Энхзаяа/-т үүрэг болгосугай.

5. Коронавируст (Ковид-19) халдвараас урьдчилан сэргийлэх талаар иргэдэд зориулсан гарын авлага, санамж, зөвлөмжийг боловсруулан, боломжит бүх хэлбэрээр сурталчилж ажиллахыг Нийгмийн Эрүүл мэндийн хэлтэс /О.Энхзаяа/, Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс /Б.Одгэрэл/ нарт тус тус даалгасугай.


6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Орлогч дарга /Л.Зэндмаа/-д даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 10 дугаар сарын 15-ний өдрийн
2/139 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ШТАБЫН ЖИЖҮҮРИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ТҮР ЖУРАМ

1. Штабын жижүүр нь батлагдсан хуваарийн дагуу Нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабын байранд 24 цагаар үүрэг гүйцэтгэнэ.

2. Үүссэн нөхцөл байдлын улмаас нийслэлийн Эрүүл мэндийн албанаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг холбогдох дарга, мэргэжилтнээс авч нэгтгэх, холбогдох албан тушаалтанг мэдээллээр хангах,

3. Штабын жижүүрээр ажиллах хугацаанд эрүүл мэндийн асуудлаар хандсан иргэдийн санал, хүсэлтийг холбогдох байгууллагад уламжлан, шийдвэрлүүлэх,

4. Доорхи мэдээ тайланг авч нэгтгэн НОК-ын дарга удирдлага, холбогдох байгууллага, албан тушаалтныг шуурхай, үнэн зөв мэдээллээр хангаж ажиллана.
Үүнд:

- Автотээврийн шалган нэвтрүүлэх товчоодын үйл ажиллагааны мэдээ,
- Угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан иргэдийн талаархи мэдээ,
- Гэрийн ажиглалт, тусгаарлалтын мэдээ,
- “Маскаа зүүцгээе, гараа угаая” 2-р аяны мэдээ, тайлан,
- Оношилгооны цэгээр үйлчлүүлсэн иргэдийн талаархи мэдээ,
- Нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбоотой эрүүл мэндийн байгууллагаас шуурхай авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны мэдээ авч нэгтгэн хүргүүлнэ.

5. Автотээврийн шалган нэвтрүүлэх товчоодын үйл ажиллагааны мэдээг батлагдсан хүснэгтийн дагуу **өдөр бүрийн 08.30 цагт товчоодоос авч нэгтгэн 09.30 цагт kovid19@gmail.com** хаягаар болон Нийслэлийн онцгой комиссын шуурхай штаб, НЭМГ-ын даргад хүргүүлнэ.

6. Угаарын хийн хордлогод өртсөн иргэдэд үзүүлсэн тусламж, үйлчилгээний талаарх мэдээг батлагдсан хүснэгт, загварын дагуу Нийслэлийн Түргэн тусламжийн төв, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн Үндэсний төв, Налайх дүүрэг, тосгодын эрүүл мэндийн төвөөс авч нэгтгэж, **08.30 цагт** багтаан НОК-ын дарга, удирдлага, ЭМЯ, НЭМГ, НЭМҮТ, НМХГ-т болон kovid19@gmail.com хаягаар НОБГ-т хүргүүлнэ.


7. Дүүрэг, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвөөс гэрийн ажиглалт, тусгаарлалтад хянагдаж байгаа иргэдийн мэдээг батлагдсан хүснэгтийн дагуу **өдөр бүрийн 16.00 цагт авч нэгтгэн 20.00 цагт**, дүүргийн хэмжээнд илэрсэн сэжигтэй тохиолдолын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаархи мэдээллийг тухай бүр Нийслэлийн онцгой комиссын шуурхай штаб, НЭМГ-ын даргад болон kovid19@gmail.com хаягаар НОБГ-т хүргүүлнэ.

8. Дүүргийн эрүүл мэндийн төвийн харьяа зарим салбар амбулаторид байгуулсан коронавируст (Ковид-19) халдварыг илрүүлэх түргэвчилсэн оношилгооны цэгээр үйлчлүүлсэн иргэдийн талаархи мэдээг батлагдсан хүснэгтийн дагуу авч нэгтгэн **өдөр бүрийн 10.00 цагт** Нийслэлийн онцгой комиссын шуурхай штаб, ЭМЯ, НЭМГ-ын даргад хүргүүлнэ.

9. “Маскаа зүүцгээе, гараа угаая” 2-р аяны мэдээ, тайланг батлагдсан хүснэгтийн дагуу дүүргийн ЗДТГ, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжүүдээс **долоо хоног бүрийн Пүрэв гаригийн 15:00 цаг** tubhealth2020@gmail.com хаягаар авч нэгтгэн, kovid19@gmail.com хаягаар НОБГ-т хүргүүлнэ.

10. Жижүүрийн хугацаанд иргэд олноор хордсон, хүний амь нас эрсэдсэн, коронавируст (Ковид-19) халдвар, ОУХХ өвчний халдварын сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн зэрэг онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд гамшиг онцгой байдлын үеийн болон түргэн тусламжийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй 99779568 дугаарын утсаар шуурхай холбогдож мэдээлнэ.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны .../... дугаар сарын ...-ний өдрийн
А/139 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН АВТО ТЭЭВРИЙН ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ТОВЧООДОД ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЯНАЛТ ХИЙХ УДИРДАМЖ

Авто тээврийн шалган нэвтрүүлэх байнгын ажиллагаатай товчоодод ажиллах эмч, эрүүл мэндийн ажилтнууд нь өдөр бүрийн 9.00 цагт хуваарьт товчоонд очсон байх ба ээлж хүлээлцэж, үүрэгт ажилдаа орно.

Тухайн ээлжинд ажиллах эмч, эрүүл мэндийн ажилтнуудын багийг байгууллагын даргын томилсон их эмч удирдаж ажиллана.

Ахлагч их эмч нь багийн гишүүдийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг шалгаж, аюулгүй ажиллагааны зааварчлагааг танилцуулж, гарын үсэг зуруулсан байна.

Ахлагч их эмч нь 24 цагийн үйл ажиллагааны мэдээг хүснэгтийн дагуу үнэн зөв гаргаж, өдөр бүрийн 08.00 цагт Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабын 11-324207 дугаарын утсаар өгнө.

Харьяа эрүүл мэндийн байгууллага нь хуваарьт авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоонд дараах бэлэн байдлыг хангасан байна.

Үүнд:


- Эрүүл мэндийн байгууллага нь бэлтгэл ажлыг хангаж, хяналтад ажиллах эмч эмнэлгийн эмч, мэргэжилтний нэрс, ажиллах өдөр бүхий хуваарийг гаргаж баталгаажуулсан байна.
- Цэгт үүрэг гүйцэтгэх эрүүл мэндийн ажилтнууд холбогдох сургалтад хамрагдсан байх бөгөөд мэргэжил арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгч ажиллана.
- Хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийг хүний тоогоор бүрдүүлэн, сэжигтэй тохиолдолд холбогдох арга хэмжээг авна. (Нэг удаагийн малгай, халад, комбинзон, нүдний шил, нүүрний хамгаалалт, амны хаалт, шүүлтүүртэй амны хаалт, хормогч, бээлий, усны гутал, улавч)
- Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэлд тавигдах шаардлагыг хангасан байх бөгөөд тухай бүрд нөхөлт, хангалтыг хийнэ.
- Эмч, эмнэлгийн ажилчид болон тээврийн хэрэгслээр зорчиж байгаа амны хаалтгүй иргэдэд зориулсан амны хаалтны нөөцтэй байх, гар угаах, халдваргүйжүүлэх нөхцөл бүрдүүлсэн байна.

Авто тээврийн шалган нэвтрүүлэх байнгын ажиллагаатай товчоодод ажиллах эмч, эрүүл мэндийн ажилтнууд нь аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж, дор дурдсан үүргийг гүйцэтгэнэ:

- Цаг агаарын байдалд тохируулан хувийн бэлтгэл ханган, дулаан хувцастай ирсэн байна.
- Тусламж, үйлчилгээ үзүүлэх газарт очихдоо байгууллагаас томилсон зориулалтын тээврийн хэрэгслээр хүргүүлнэ.
- Үйл ажиллагаандаа холбогдох тушаал, шийдвэр, журам, дүрмийг баримтлан ажиллана.

- Эрүүл мэндийн хяналтыг цагдаагийн албан хаагч тээврийн хэрэгслийг бүрэн зогсоосны дараа эхлэх ба бусад үед замын зорчих хэсэгт орохыг хатуу хориглоно.
- Нийслэлээс гарч, орж буй тээврийн хэрэгслээр зорчиж байгаа иргэдийг хяналтад бүрэн хамруулах ба зорчигчдод эрүүл мэндийн хяналтын үйл ажиллагааны талаар танилцуулан, үнэн зөв мэдээлэл өгөхийг сануулж ажиллана.
- Тээврийн хэрэгслээр зорчиж буй иргэн бүрийн биеийн халууныг зайнаас хэмжигчээр бугуй, эгэм, дух орчимд хэмжиж үзэх ба эрүүл мэндийн асуумжийг хүн бүрээс авна.
- Асуумж судалгаагаар 37,1 хэмээс дээш халуунтай, тархвар зүйн өгүүлэмжтэй тохиолдолд сэжигтэй гэж үзэж, зорчиж яваа автомашинтай нь замын хажууд тогтоосон газарт түр тусгаарлах ба зорчигч болон хамт яваа хүмүүст амны хаалт зүүлгэн, бээлий өмсгөж холбогдох бүртгэлийг хүснэгтийн дагуу хүн бүрээр бүрэн хөтөлнө.
- Сэжигтэй тохиолдол илэрсэн тухай байгууллагын дарга, ХӨСҮТ-ийн 80086829, 100 дугаарын утсанд шуурхай мэдээлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө авна.
- Сэжигтэй зорчигчийн биеийн байдалд үзлэг хийж, шаардлагатай тохиолдолд яаралтай болон амилуулах суурь тусламжийг стандартын дагуу үзүүлж, яаралтай тусламж үзүүлсэн тохиолдолд яаралтай тусламжийн хуудсыг 2% хөтөлж, нэг хувийг шилжүүлэн авч буй эрүүл мэндийн байгууллагын эмчид өгнө.
- Сэжигтэй тохиолдол гэж үзсэн зорчигч, хавьтлыг шилжүүлсний дараа тухайн тээврийн хэрэгсэл болон тусгаарласан байр, товчоонд эцсийн халдваргүйтгэлийг хийлгэнэ.


Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 7/1 дугаар сарын 15-ний өдрийн
А/139 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ ТОВЧООДООР НЭВТЭРЧ БҮЙ
ЗОРЧИГЧДОД ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЯНАЛТ ХИЙХ ХУВААРЬ

| № | Товчооны нэр | Ажиллах байгууллага | Хариуцах албан тушаалтан | Утасны дугаар |
|---|---------------------------------------|---|--|---------------|
| 1 | 4-р зөрлөг | НДЭМТ БЗНЭ-2 | Б.Тунгалаг /НДЭМТ-ийн Дотоод хяналт хариуцсан ажилтан/ | 89918099 |
| 2 | Элстэйн товчоо | Амгалан АГ-2 Бяцхан тэмүүлэл ХСЗТөв-8 | | |
| 3 | Тавантолгойн товчоо /Морингийн даваа/ | БЗДЭМТ Энэрэл эмнэлэг -4 СЗКЭ-2 | Ц.Саранцэцэг /БЗДЭМТ-ийн ЭЭО Дарга/ | 99192547 |
| 4 | Айдсын даваа товчоо | ХУДЭМТ ХУНЭ-2 Хан туул ХСЗТөв-8 | Б.Лувсанням /ХУДЭМТ-ийн НЭМО Дарга/ | 99044630 |
| 5 | Баруун-туруун товчоо | СБДЭМТ СХДЭМТ СХНЭ-2 ШЭНТ-2 | Т.Ундрах /СБЭМТ-ийн Поликлиникийн эрхлэгч/ | 99800314 |
| | | | Л.Лхагвадорж /СХДЭМТ-ийн ТБХЗА Дарга/ | 96663853 |
| 6 | Ар Гүнтийн товчоо | ЧДЭМТ Хүрээ АГ-2 | Г.Эрболд /ЧДЭМТ-ийн НЭМ-ийн ТХХЗохицуулагч/ | 80065757 |
| 7 | Эмээлтийн товчоо | БГДЭМТ Наркологи-2 Өргөө АГ-2 Эрүүл үрс ХСЗТөв -10 | Г.Идэр / БГДЭМТ-ийн НЭМО Дарга/ | 88840601 |
| 8 | Багахангайн товчоо | БХЭМТөв СБНЭ-2 | Г.Гантуяа /БХДЭМТ-ийн Хүний нөөцийн менежер/ | 88251080 |
| 9 | Хэрлэнгийн гүүр товчоо | БНДЭМТ НЗӨСТ-2 | З.Дэлгэрмаа /БНДЭМТ-ийн НЭМО Дарга/ | 99038148 |

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 11 дугаар сарын 15-ний өдрийн
4139 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУМЖ

2020.... сарынөдөр

1. Овог.....
2. Нэр.....
3. Хүйс Эр Эм /доогуур нь зурна уу/
4. Иргэншил.....
5. Регистр.....
6. Гэрийн хаяг.....
7. Утасны дугаар.....
8. Шаардлагатай үед холбоо барих хүний нэр, утасны дугаар
.....
9. Танайд гадаад орноос тусгай үүргийн онгоцоор ирсэн, сэжигтэй, өвчтэй
тохиолдлын хавьтлын улмаас тусгаарлалт, ажиглалтанд орсон хүн байгаа,
байсан эсэх
Тийм Үгүй /доогуур нь зурна уу/
10. Танд дараах шинж тэмдэг илэрч байвал + тэмдэг тавина уу?

| № | Илэрсэн шинж тэмдэг | + | - | Илэрсэн шинж тэмдэг | + | - |
|---|---------------------------------------|---|----|-----------------------|---|---|
| 1 | 37,1 ⁰ С-ээс дээш халуурах | | 6 | Хоолны амт өөрчлөгдөх | | |
| 2 | Толгой өвдөх | | 7 | Хамраас нус гоожих | | |
| 3 | Нүд улайх | | 8 | Бөөлжих | | |
| 4 | Хоолой өвдөх | | 9 | Суулгах | | |
| 5 | Ханиалгах | | 10 | Бие сулрах | | |

АСУУМЖ АВСАН:

Албан тушаал

Овог, нэр

Гарын үсэг

.....

.....

.....

